

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/158/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Назгүл
	Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт.....	16
Төлбөрийн акт тогтоогдоогүй.....	16
5.2 Албан шаардлага.....	16
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ТОЛБО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.ХУРМАНГАЗ ТАНАА

2024.02.14 № 95
танай- -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дүгнэлт-ЗДТГ 02.14Толбо сумын Засаг даргын тамгын газар

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

Дүгнэлт-ЗДТГ 02.14Толбо сумын Засаг даргын тамгын газар

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>60,953,246.67</u>	<u>67,543,628.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	100.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	100.00	-
3121	Төгрөг	100.00	-
31211	Төрийн сангийн харилцах	100.00	-
33	АВЛАГА	4,557,518.67	8,473,000.00
335	Бусад авлага	4,557,518.67	8,473,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,557,518.67	8,473,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	56,395,628.00	59,070,628.00
354	Хангамжийн материал	56,395,628.00	59,070,628.00
35410	Бичиг хэргийн материал		275,000.00
35420	Аж ахуйн материал	30,895,628.00	8,895,628.00
35470	Бусад хангамжийн материал	25,500,000.00	49,900,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,218,176,895.50</u>	<u>4,403,130,774.60</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,218,176,895.50	4,403,130,774.60
392	Биет хөрөнгө	1,201,514,895.50	4,386,468,774.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	978,071,931.00	968,071,931.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(360,664,049.07)	(397,387,053.54)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	148,629,994.00	131,639,994.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(140,408,747.00)	(123,903,745.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	500,721,934.00	557,412,734.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(272,903,352.30)	(312,635,118.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,372,872.00	18,372,872.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,156,857.26)	(13,922,302.92)
39209	Зам, гүүрийн байгууламж	39,500,000.00	39,500,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(329,166.67)	(4,279,166.71)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5,234,600.00	5,234,600.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	451,134,580.00	3,735,466,488.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(153,688,843.20)	(217,102,457.13)
393	Биет бус хөрөнгө	16,662,000.00	16,662,000.00
39301	Програм хангамж	1,486,400.00	1,486,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,486,400.00)	(1,486,400.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,662,000.00	16,662,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,279,130,142.17</u>	<u>4,470,674,402.60</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>3,809,715.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,809,715.00
413	Өглөг	-	3,809,715.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	3,809,715.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,279,130,142.17</u>	<u>4,466,864,687.60</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,279,130,142.17	4,466,864,687.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	490,884,758.00	490,884,758.00
51101	Өмч: - төрийн	490,884,758.00	490,884,758.00
512	Хуримтлагдсан үр дүн	358,159,594.76	3,545,894,140.19
51210	Өмнөх үеийн үр дүн	358,159,594.76	358,159,594.76
51220	Тайлант үеийн үр дүн	-	3,187,734,545.43

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	430,085,789.41	430,085,789.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,279,130,142.17</u>	<u>4,470,674,402.60</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	605,772,285.00	3,921,290,597.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,500,000.00	3,337,716,808.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	3,337,716,808.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	3,317,716,808.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	20,000,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	39,500,000.00	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	39,500,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	566,272,285.00	583,573,789.34
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,693,575.00	33,538,091.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,488,400.00	1,837,591.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,205,175.00	31,700,500.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	553,578,710.00	550,035,698.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	406,146,610.00	550,035,698.34
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	19,500,000.00	-
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	127,932,100.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	581,477,373.12	733,556,051.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	581,477,373.12	733,556,051.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	514,185,986.12	725,175,797.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,969,659.00	391,385,422.34
210101	Үндсэн цалин	187,855,577.00	274,318,745.45
210102	Нэмэгдэл	45,854,172.00	110,436,636.89
210104	Урамшуулал	-	6,630,040.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,259,910.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,786,939.00	49,448,999.00
210201	Тэтгэврийн даатгал	23,468,139.00	33,625,538.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,329,700.00	3,955,938.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,863,700.00	3,164,372.00
210204	Ажилгүйдлийн даатгал	466,000.00	791,066.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,659,400.00	7,912,085.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,683,700.00	25,257,401.00
210301	Гэрэл, цахилгаан	1,865,000.00	1,099,501.00
210302	Түлш, халаалт	18,818,700.00	24,157,900.00

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	23,774,040.00	23,173,504.00
210401	Бичиг хэрэг	2,121,000.00	1,820,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,506,100.00	17,330,604.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,059,040.00	3,695,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	87,900.00	327,000.00
2105	Нормативт зардал	457,000.00	430,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	430,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,814,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	714,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,666,000.00	2,812,000.00
210702	Дотоод албан томилолт	2,666,000.00	2,812,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,699,360.00	32,237,124.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	529,200.00	31,417,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	362,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	145,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,660.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	379,700.00	532,100.00
210807	Газрын төлбөр	37,300.00	97,624.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	75,000.00	45,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	169,049,288.12	198,617,347.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,911,400.00	48,834,518.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	714,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	118,737,888.12	149,068,828.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,291,387.00	8,380,254.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	30,418,400.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	30,418,400.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,753,200.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,733,200.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,020,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,119,787.00	8,380,254.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,119,787.00	8,380,254.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	24,294,911.88	3,187,734,545.43
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,350,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(7,350,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	16,944,911.88	3,187,734,545.43

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	449,259,185.00	583,573,789.34

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	449,259,185.00	583,573,789.34
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,693,575.00	33,538,091.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,488,400.00	1,837,591.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,205,175.00	31,700,500.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	436,565,610.00	550,035,698.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	406,146,610.00	550,035,698.34
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	30,419,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	467,277,985.00	567,267,989.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	467,277,985.00	567,267,989.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	399,986,598.00	558,887,735.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,969,659.00	387,575,707.34
210101	Үндсэн цалин	187,855,577.00	270,016,602.45
210102	Нэмэгдэл	45,854,172.00	110,929,064.89
210104	Урамшуулал		6,630,040.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,259,910.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,786,939.00	49,448,999.00
210201	Тэтгэврийн даатгал	23,468,139.00	33,625,538.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,329,700.00	3,955,938.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,863,700.00	3,164,372.00
210204	Ажилгүйдлийн даатгал	466,000.00	791,066.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,659,400.00	7,912,085.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,683,700.00	25,257,401.00
210301	Гэрэл, цахилгаан	1,865,000.00	1,099,501.00
210302	Түлш, халаалт	18,818,700.00	24,157,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,774,040.00	23,248,504.00
210401	Бичиг хэрэг	2,121,000.00	1,820,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,506,100.00	17,330,604.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,059,040.00	3,770,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	87,900.00	327,000.00
2105	Нормативт зардал	457,000.00	430,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	430,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,814,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		714,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,666,000.00	2,812,000.00
210702	Дотоод албан томилолт	2,666,000.00	2,812,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,699,360.00	36,237,124.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	529,200.00	35,417,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	362,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	145,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,660.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	379,700.00	532,100.00
210807	Газрын төлбөр	37,300.00	97,624.00

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	75,000.00	45,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,849,900.00	32,064,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,449,900.00	31,350,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	714,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,291,387.00	8,380,254.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	30,418,400.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	30,418,400.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,753,200.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,733,200.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,020,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,119,787.00	8,380,254.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,119,787.00	8,380,254.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(18,018,800.00)	16,305,800.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	16,305,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	16,305,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	16,305,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		16,305,900.00
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(16,305,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(18,018,800.00)	(100.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,018,900.00	100.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	100.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	358,159,594.76	1,279,130,142.17
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	358,159,594.76	1,279,130,142.17
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D08	Тайлант үеийн үр дүн			3,187,734,545.43	3,187,734,545.43
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	3,545,894,140.19	4,466,864,687.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		100.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	568,425,300.00	547,660,731.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	568,425,300.00	547,660,731.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	567,711,300.00	547,660,731.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	400,593,400.00	387,575,707.34
210101	Үндсэн цалин	279,461,600.00	270,016,602.45
210102	Нэмэгдэл	116,131,800.00	110,929,064.89
210104	Урамшуулал	5,000,000.00	6,630,040.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,074,200.00	49,448,999.00
210201	Тэтгэврийн даатгал	34,050,400.00	33,625,538.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,006,000.00	3,955,938.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,204,700.00	3,164,372.00
210204	Ажилгүйдлийн даатгал	801,200.00	791,066.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,011,900.00	7,912,085.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,282,900.00	25,257,401.00
210301	Гэрэл, цахилгаан	1,125,000.00	1,099,501.00
210302	Түлш, халаалт	24,157,900.00	24,157,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,365,600.00	22,365,600.00
210401	Бичиг хэрэг	1,820,000.00	1,820,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,447,700.00	16,447,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,770,900.00	3,770,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000.00	327,000.00
2105	Нормативт зардал	430,000.00	430,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000.00	430,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,885,000.00	1,814,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	714,000.00	714,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	71,000.00	
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,037,000.00	2,812,000.00
210702	Дотоод албан томилолт	3,037,000.00	2,812,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,629,200.00	52,543,024.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,584,200.00	51,417,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	365,500.00	

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	180,600.00	145,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,800.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	838,000.00	838,000.00
210807	Газрын төлбөр	131,000.00	97,624.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,100.00	45,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,414,000.00	5,414,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,700,000.00	4,700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	714,000.00	714,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	714,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	714,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	714,000.00	
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	568,425,300.00	547,660,631.34
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	568,425,300.00	547,660,631.34
132001	Орон нутгийн төсвөөс	568,425,300.00	547,660,631.34
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	4	4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.0	25.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.0	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.0	8.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.0	8.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,538,091.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,538,091.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,532,904.00
2104	Хангамж, бараа материалын зардал	882,904.00
210402	Тээвэр, шатахуун	882,904.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,650,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,650,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,005,187.00

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,005,187.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	6,005,187.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,538,091.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,538,091.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,837,591.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,700,500.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөгөө зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ИТХ, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд “Удирдлага болон нөөцийн үр ашгийг дээшлүүлж төрийн үйлчилгээний шуурхай байдал чанар хүртээмжийг сайжруулах” зорилго дэвшүүлсэн байна. Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажиллажээ.

- Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг ажилдаа мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх
- Үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажлыг сайжруулах
- Ажлын цагийн ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдлыг хангах
- Байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын алба 2023 онд төлөвлөгөөт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/19 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,191.5 сая төгрөгөөр буюу 249.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.10	0.00	-0.10
Авлага	4,557.52	8,473.00	3,915.48
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	56,395.63	59,070.63	2,675.00
Үндсэн хөрөнгө	1,218,176.90	4,403,130.77	3,184,953.88
Нийт хөрөнгө	1,279,130.14	4,470,674.40	3,191,544.26
Өр төлбөр	0.00	3,809.72	3,809.72
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,279,130.14	4,466,864.69	3,187,734.55
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,279,130.14	4,470,674.40	3,191,544.26

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Авлага данс оны эхэнд хувь хүмүүсээс авах өвс, тэжээлийн үнийн 4.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсныг барагдуулж дахин зээлээр өвс, тэжээл тарааж, оны эцэст хувь хүмүүсээс авах 8.5 сая төгрөгийн авлагатай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 59.1 сая төгрөг болж оны эхнээс 2.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Бичиг хэргийн материалын үлдэгдэл 0.3 сая, аж ахуйн материал 8.9 сая, бусад хангамжийн материал 49.9 сая төгрөг байна. Төсвийн хөрөнгөөр 58.9 сая төгрөгийн материал худалдан авч, Орон нутгийн хөгжлийн сангаас үнэ төлбөргүй 20.0 сая төгрөгийн бараа материал авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,184.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр 16.3 сая төгрөгийн, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 2,840.6 сая төгрөгийн хар зам, 82.5 сая төгрөгийн сумын ерөнхий төлөвлөгөө, 19.5 сая төгрөгийн хадлан хамгаалах хашаа, 29.4 сая төгрөгийн худаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 322.3 сая төгрөгийн, байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгөөр 20.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 3,317.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Засгийн газрын оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр -3,187.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 576.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 130.7 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 8.7 сая, хангамж, бараа материалын зардлыг 7.0 сая нормативт зардлыг 0.2 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 4.6 сая, томилолт зочны зардлыг 4.2 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 1.4 сая төгрөгөөр тус тус бууруулж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 55.5 сая, урсгал шилжүүлгийг 0.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Тус байгууллагын 2023 оны анх батлагдсан төсөв 475.4 сая төгрөг байна. Үүнд: Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 475.4 сая төгрөгөөр баталсан байна.

Батлагдсан төсвийг 93.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 568.4 сая төгрөгөөр тодотгож баталсан байна

Анх батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 86.7 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 10.8 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 4.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, хангамж, бараа материалын зардлыг 3.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 6.0 сая төгрөгөөр бууруулж, нийт 93.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Төрийн албан хаагчдын цалин 2023 онд үнэмлэхүй хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлуудыг нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 568.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 547.7 сая төгрөгийн санхүүжилт авч, зарцуулсан байна.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 547.7 сая төгрөг буюу 96 хувьтай байна. Энэ нь орон нутгийн төсвөөс 18.4 сая төгрөгийг дутуу олгосонтой болон авсан санхүүжилтээс 2.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага				
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	400,625.80	387,770.09	-12,855.71	97%
2	Туслах үйл ажиллагааны зардал	108,385.50	106,265.15	-2,120.36	98%
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	714.00	0.00	-714.00	0%
4	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөний тэтгэмж	0.00	-0.10	-0.10	
5	Орон нутгийн нөөц хөрөнгө	3,200.00	3,200.00	0.00	100%
6	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	55,500.00	50,425.50	-5,074.50	91%
	Дүн	568,425.30	547,660.63	-20,764.67	96%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 1.8 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 31.7 сая, нийт 33.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан. Үүнээс 0.9 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 26.7 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж, 6.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 58.9 сая төгрөгийн бараа материал, 16.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Толбо сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 3/41 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 581.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 11.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн 36 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгаж хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтыг зөрчиж зочин төлөөлөгч хүлээн авч 500.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл гардуулж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансанд байршуулах мэдээллийг бүрэн оруулсан байна. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Алдаа зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийтдээ 152.3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөнийг давтан шалгахад зөрчлийг арилгасан байна.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0		0		
Албан шаардлага	0		0		
Зөвлөмж	2	152,296.7	2	152,296.7	100%
Нийт дүн	2	152,296.7	2	152,296.7	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26.2 сая төгрөгийн алдаа¹ илэрч аудитын явцад залрууллаа. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрт 2.4 сая төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг оруулж тайлагнасан, ажиллагсадтай холбоотой 3.8 сая төгрөгийг өр төлбөрийг байгууллагад төлөх өглөгөөр тайлагнасан, үнэ төлбөргүй хүлээж авсан 20.0 сая төгрөгийн бараа материалыг хөрөнгийн санхүүжилтээр бүртгэж тайлагнасан нийт 26.2 сая төгрөгийн алдааг залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар зөрчил² илрээгүй.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс		Зөвлөмж
				Залруулсан	Залруулаагүй	

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайланд өр төлбөр, хөрөнгийн санхүүжилт, санхүүжих эх үүсвэрийг алдаатай тайлагнасан..	1	26,184.8			1	26,184.8	1	26,184.8				
Дүн	1	26,184.8			1	26,184.8	1	26,184.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								